



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/433

Мөрөн сум

Гэрээ байгуулах эрх олгож,
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 45 дугаар зүйлийн 45.3, 46 дугаар зүйлийн 46.1.3, 46.1.6, 46.3, Засгийн газрын 2021 оны “Журам батлах тухай” 160 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2022 оны А/95 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн зураг төслийн сангийн хөрөнгөөр санхүүжихээр батлагдсан Сумын төвийн хогийн цэгийг дарж булшлах ажлын /Тариалан сум/ зураг төсөл боловсруулах зөвлөх сонгох ХӨАОНӨГ/202302099 дугаартай тендерт 34,313,793 (Гучин дөрвөн сая гурван зуун арван гурван мянга долоон зуун ерэн гурван) төгрөгийн үнийн санал ирүүлсэн “Би Ди Инженеринг” ХХК-ийн тендерийг зөвшөөрч, тус компанид гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэсүгэй.

2. “Би Ди Инженеринг” ХХК-ийн гэрээтэй холбоотой асуудлаар захиалагчийг төлөөлж харилцах, холбогдох шийдвэрийг гаргах, зөвлөх үйлчилгээний гэрээний нөхцөлүүдийн хэрэгжилтэд хяналт тавих зөвлөх үйлчилгээг хүлээн авах, гэрээ дүгнэх чиг үүрэг бүхий “Захиалагчийн төлөөлөгч”-өөр аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Б.Оюунтуяа)-г томилж, зөвлөх үйлчилгээ хүлээн авах, нийлүүлэгчтэй байгуулсан гэрээг дүгнэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Захиалагчийн төлөөлөгч: Б.Оюунтуяа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга)

Ажлын хэсгийн гишүүд: Б.Энхжаргал (Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилгын хэлтсийн дарга)

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга: Б.Минжүүржаргал (Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах албаны мэргэжилтэн)

3. Сумын төвийн хогийн цэгийг дарж булшлах ажлын /Тариалан сум/ зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ нийлүүлэх гэрээнд заасан захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх, гэрээний хэрэгжилтийг хангах, зөвлөх үйлчилгээг хүлээн авах, гэрээг дүгнэх, санхүүжилтийн гүйцэтгэл баталгаажуулах, гэрээ болон гэрээний хэрэгжилтийн мэдээллийг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем, хөрөнгө оруулалтын үр ашгийг үнэлэх цогц системд тус тус нийтлэх, захиалагчийн төлөөлөгчийн чиг үүрэг хэрэгжүүлсэн тухай ажлын үр дүнг тайлагнах, тайланг хавтаст хэрэг болгон архивд шилжүүлэх зэрэг үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулахыг захиалагчийн төлөөлөгч

(Б.Оюунтуяа)-д, захиалагч, тендерт оролцогч (тухайн тендерт оролцсон нийт оролцогч)-ийн тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг зохион байгуулсан баримт бичиг, гэрээ дүгнэсэн акт, зөвлөх үйлчилгээ хүлээн авсан шийдвэр, санхүүжилтийн гүйцэтгэл зэрэг баримт бичгийг цахим болон бичгийн хэлбэрээр хавтаст хэрэг болгон архивд шилжүүлэхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Д.Төмөр)-д тус тус даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Должинсорогдог)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш. ИДЭРБАЯСГАЛАН